



“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ”ХК

“ЭРДЭНЭС-ТАВАНТОЛГОЙ” ХК-Д ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ
БУТЛАХ МАШИН, ХОГ ХАЯГДАЛ АРИУТГАХ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХ
АВТОКЛАВ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Тендер шалгаруулалтын дугаар

ЭТТ/202001142

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр

“Эрдэнэс-Тавантолгой” ХК нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос “Эмнэлгийн аюултай хог хаягдал бутлах машин, хог хаягдал ариутгах халдвартгуйжүүлэх автоклав”-ыг нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 00 минутаас өмнө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын худалдан авах ажиллагааны www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 12 цаг 30 минутад нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн талаарх бусад мэдээллийг доорхи хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жигжиджав-8,
Финанс төв, 5 давхар 503 тоот
Утас: +976-7505-5555-511

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өтөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
 - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
 - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
 - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Сүүлийн 1 жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан.</p> <p>2. 2018, 2019 оны аль нэг жилд ижилд төстэй бараа нийлүүлж байсан туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн 1-ээс доошгүй ажлын гэрээний хуулбар/.</p> <p>3. Компанийн танилцуулга.</p> <p>4. Компанийн гэрчилгээний хуулбар.</p> <p>5. Татварын тодорхойлолт нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-д тендер нээх өдрийн байдлаар өргүй байх.</p> <p>6. Шүүхийн төрөлжсөн архивын газрын тодорхойлолт ирүүлэх.</p> <p>/тендер зарласан өдрөөс хойши хойши байдлаар/</p> <p>7. ШШГЕГ-ын тодорхойлолт. /тендер зарласан өдрөөс хойши хойши байдлаар/</p> <p>8. Тендерт шалгарсан тохиолдолд техникийн тодорхойлолтын шаардлага хангаагүй бараа нийлүүлвэл захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх.</p> <p>9. Тендерт шалгарсан тохиолдолд тендерт санал болгосон хугацаандаа нийлүүлээгүй бол захиалагчийн саналаар гэрээг цуцлахад татгалзах зүйлгүй талаарх албан бичиг ирүүлэх.</p> <p>10. Техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан баримт бичгийг ирүүлэх.</p> <p>11. Баталгаат хугацаа багадаа 1 жил байх бөгөөд баталгаат хугацааны үед ашиглалтын бус эвдрэл гэмтэл гарсан тохиолдолд сольж өгөхийг зөвшөөрсөн албан бичиг ирүүлэх.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах тусгай зөвшөөрөлтэй байх шаардлагатай эсэх: Үгүй</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Хаяг: Цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр /pdf/-ээр илгээнэ.</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 12 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жижиджав-8, Финанс төв, Утас: +976-7505-5555-511</p> <p>Давхар болон өрөөний дугаар: 5 давхар 503 тоот</p> <p>Огноо: 2020 оны 03 дугаар сарын 06-ны өдөр</p> <p>Цаг: 12 цаг 30 минутад нээнэ.</p>
ТОӨЗ 6.2	<p>1. Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй</p>

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

№	Зорилго	Тоо ширхэг	Бараа бүтээгдэхүүний тодорхойлолт	Зураг
1	Хог хаягдлын уут /Тасаг нэгжүүд, лаборторийн газраас халдвартай хог хаягдал цуглуулахад ашиглах хэрэгсэл	500 ш	Зузаан 7 микронос доошгүй, Зөвхөн 1 удаа ашиглагдана, Автоклавд хийх бүрэн боломжтой	
2	Аюултай хог хаягдал цуглуулах сав /Аюултай хог хаягдлыг тасаг нэгжүүдэд түр хадгалах , тээвэрлэх	7 ш	Материал –Нягтрал сайтай хуванцар, Хөнгөн зөөхөд хялбар, Хүчил шүлтэнд тэсвэртэй, 2 талдаа бариултай, Таг нь түгжигддэг, Шар өнгөтэй, “Биоаюултай” таних тэмдэгтэй, 60 л-ийн багтаамжтай	
3	Хог хаягдлын сав /Халдвартай хог хаягдлыг цуглуулахад ашиглагдана/	5 ш	Хуванцар (ПЕ полиэтилон), Хөнгөн зөөхөд хялбар, Халдвартай хог хаягдлыг цуглуулахад ашиглагдана/	
4	Ахуйн хог хаягдлыг зөөвөрлөх зориулалт бүхий дугуйтай сав /Ахуйн хог хаягдал ууттай хогийг цуглуулах зөөвөрлөх	7 ш	Өндөр нягтралтай хуванцар, Хатуу хог хаягдал хийх зориулалттай, Хэт ягаан тuyaатай өндөр хэмд тэсвэртэй, Гөлгөр гадаргуутай, Хими болон биологийн нөлөөнд тэсвэртэй	
5	Бага оврийн автоклав /Халдвартай хог хаягдал халдвартай хогийг дахин зориулалт бүхий автоклав/	1 ш	Цахилгаан тэжээл 220/В/, Камерын хэмжээ 60 литрээс багагүй, Зэвэрдэггүй ган, Температур 121С, 134 С	
6	Хог бутлагч /Автоклаваас гарсан хогийг дахин ашиглахааргүй болтол бутлаж үйрүүлнэ/	1 ш	Бутлагч машин нь автоклаваас ариутгагдаад гарсан хогийг дахин ашиглагдахааргүй болтол буталж үйрүүлнэ. Цагт 60-80 кг хог хаягдал бутлах хүчин чадалтай байх	
7	Электрон жин /Эрүүл мэндийн байгууллагын бүх төрлийн хог хаягдлыг жигнэх/	1 ш	Цэвэрлэх халдвартай хогийг дахин зориулалт бүх төрлийн хог хаягдлыг жигнэх/	

8	Аюултай хог хаягдал цуглуулах , зөөх тэргэнцэр /Аюултай хог хаягдал бүхий савыг зөөвөрлөх/	1 ш	Зөөвөрлөхөд хялбар дугуйтай, Төмөр металл	
10	Бараанд дагалдах үйлчилгээ		Хүргэх, суурилуулах, ашиглах талаар зааварчилгаа өгөх	

- 1. Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- 2. Бараа хүргэх газар:** [Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сум дундын эмнэлэгт]
- 3. Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхой лолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүл эгчийн санал болгосо н хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Хог хаягдлын уут /Тасаг нэгжүүд, лаборторийн газраас халдвартай хог хаягдал цуглуулахад ашиглах хэрэгсэл	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	500	ш	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сум дундын эмнэлэгт	Гэрээ байгуулагдсанас хойш 7 хоногийн дотор	Гэрээ байгуулагдсанас хойш 10 хоногийн дотор	
Аюултай хог хаягдал цуглуулах сав /Аюултай хог хаягдлыг тасаг нэгжүүдэд түр хадгалах , тээвэрлэх	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	7	ш	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сум дундын эмнэлэгт	Гэрээ байгуулагдсанас хойш 7 хоногийн дотор	Гэрээ байгуулагдсанас хойш 10 хоногийн дотор	
Хог хаягдлын сав /Халдвартай хог хаягдлыг цуглуулахад ашиглагдана/	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	5	ш	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сум дундын эмнэлэгт	Гэрээ байгуулагдсанас хойш 7 хоногийн дотор	Гэрээ байгуулагдсанас хойш 10 хоногийн дотор	

Ахуйн хог хаягдлыг зөөвөрлөх зориулалт бүхий дугуйтай сав /Ахуйн хог хаягдал ууттай хогийг цуглуулах зөөвөрлөх	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	7	ш	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сүм дундын эмнэлэгт	Гэрээ байгуулагдсанаас хойшиг 7 хоногийн дотор	Гэрээ байгуулагдсанасаас хойшиг 10 хоногийн дотор	
Бага оврийн автоклав /Халдвартай хог хаягдал халдвартгыжүүлэх зориулалт бүхий автоклав/	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	1	ш	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сүм дундын эмнэлэгт	Гэрээ байгуулагдсанаас хойшиг 7 хоногийн дотор	Гэрээ байгуулагдсанасаас хойшиг 10 хоногийн дотор	
Хог бутлагч /Автоклаваас гарсан хогийг дахин ашиглахааргүй болтол бутлаж үйрүүлнэ/	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	1	ш	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сүм дундын эмнэлэгт	Гэрээ байгуулагдсанаас хойшиг 7 хоногийн дотор	Гэрээ байгуулагдсанасаас хойшиг 10 хоногийн дотор	
Электрон жин /Эрүүл мэндийн байгууллагын бүх төрлийн хог хаягдлыг жигнэх/	Техникийн тодорхойл олтод заасны дагуу	1	ш	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын сүм дундын эмнэлэгт	Гэрээ байгуулагдсанаас хойшиг 7 хоногийн дотор	Гэрээ байгуулагдсанасаас хойшиг 10 хоногийн дотор	

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойло лт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тэндерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [moo] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан moo] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|-----------------------------------------------------------------|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1. Шалгах болон турших
(ГЕН – 1) | 1.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлд заасны дагуу барааг хүлээн авах үед Захиалагч талаас томилсон эрх бүхий этгээд барааг шалгаж хүлээн авна. Барааг шалгахтай холбоотой бүхий л зардлыг Гүйцэтгэгч тал хариуцна. |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт
(ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:
1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| 3. Төлбөр
(ГЕН – 7) | 4.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:
Гэрээнд заасан барааг 100 хувь нийлүүлсэн болохыг нотолсон барааг хүлээн авсан акт, нэхэмжлэх болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн ажлын 5 хоногийн дотор нийлүүлэгч талд бүрэн төлнө. |
| 4. Алданги оногдуулах
(ГЕН - 9) ¹ | 6.1. Алданги ноогдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн [0.5%] байна.

Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн [10 хувь] байна. |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нэгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны _____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны _____ дугаар сарын _____-наас _____ оны _____ дугаар сарын _____-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]